

БАТЛАВ:
ХОВД АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ
ДАРГА **С.ГАНТӨМӨР**

Огноо: 2019.09.13

ХОВД ХОТЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГҮҮДИЙН
ОРЧИМД БАЙГАА АВТО ЗАМУУДАД ХУРД СААРУУЛАГЧ ХИЙХ

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр:

ХОВД ХОТЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГҮҮДИЙН ОРЧИМД БАЙГАА
АВТО ЗАМУУДАД ХУРД СААРУУЛАГЧ ХИЙХ

Тендер шалгаруулалт

/ гэрээний дугаар:

ХОАЖСЗДТГ/201902001

Ховд хот
2019 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2019 оны 09 дүгээр сарын 16

[Жаргалант сумын ЗДТГазар] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос *[Ховд хотын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн орчимд байгаа авто замуудад хурд сааруулагч хийх]*-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг *төрийн худалдан авах ажиллагааны цахим систем буюу www.tender.gov.mn-ээс үнэ төлбөргүй авах ба Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ.*

Цахим тендер зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамжийг www.tender.gov.mn-ээр банкны и-меркантын системийг ашиглан төлнө.

Үнийн саналыг *[2019 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн Улаанбаатарын цагаар 15 цаг 00 минутаас]*-аас өмнө *[www.tender.gov.mn хаягаар, цахим хэлбэрээр]* хэлбэрээр ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан *[2019 оны 09 дүгээр сарын 24]-* ны өдрийн *Улаанбаатарын цагаар [15 цаг 30 минутад]*¹-т нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: *Эрхгүй*
Дотоодны давуу эрх тооцох эсэх: *Тооцохгүй*

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

[Ховд аймаг, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын байр, 105 тоот өрөө, Хотын захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн Х.Баярлах, Харилцах утас: 89565689, 8828-3737]

¹ Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**

4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.

4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.

4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**

6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:

 - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;

- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТООЗ-ны холбогдох заалт	Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ Шалгуур үзүүлэл
ТООЗ 1.1	<p>Тендерт оролцогч нь Жаргалант сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 15 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Ховд аймгийн Жаргалант сумын Хотын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн орчимд байгаа авто замуудад хурд сааруулагч хийх ХОАЖСЗДТГ/201902001 дугаартай ажлыг гүйцэтгэх үнийн саналыг дараах мэдээллийн хамт ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар 2. 2018 оны санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт; 3. Татварын тодорхойлолт (татварын бар код бүхий тодорхойлолт), 4. Шүүхийн тодорхойлолт 5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт 6. Харилцагч банкны тодорхойлолт, 7. Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт /шимтгэлийн өртэй эсэх, нийгмийн даатгалд шимтгэл төлдөг хүмүүсийн жагсаалт/, 8. Ажлын төсөв ирүүлнэ /зураг төсвийн үнэ 150,000 төгрөгийг тусгана/ 9. Авах боломжтой зээл, эргэлтийн хөрөнгийн нийт дүн: Төсөвт өртөгөөс дээш. 10. Албан мэдэгдэл /ТООЗ-нд заасан/ Байгууллагын тодорхойлолтуудыг тендер зарласан өдрөөс хойш гаргасан байна. 11. Ажил гүйцэтгэх хугацааны график ирүүлнэ. 12. Авто зам, замын байгууламж барих, засварлах тусгай зөвшөөрөл
ТООЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг нь: Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ.</p> <p>Тендер шалгаруулалт / Гэрээний дугаар: Ховд аймгийн Жаргалант сумын Хотын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн орчимд байгаа авто замуудад хурд сааруулагч хийх ХОАЖСЗДТГ/201902001</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь 2019 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн Улаанбаатарын цагаар 15 цаг 00 минут байна. Энэхүү тендер нь цахим тендер тул тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn –ийн серверийн буюу Улаанбаатарын цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийг хүлээн авах боломжгүйг анхаарна уу.</p> <p>Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>
ТООЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Тендерийг 2019 оны 09 дүгээр сарын 24-ны өдөр Улаанбаатарын цагаар 15 цаг 30 минут-д Ховд аймаг, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын байр, 105 тоот өрөөнд нээнэ. Харилцах утас: 89565689,9943-8182</p>
ТООЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: [Хотын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн орчимд байгаа авто замуудад хурд сааруулагч хийх ХОАЖСЗДТГ/201902001]</p>

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Батлав. Жаргалант сумын
Засаг дарга С.Гантөмөр

Ховд хотын сургууль, цэцэрлэгийн дэргэдэх авто замд хурд сааруулагч суурьлуулах ажлын техникийн тодорхойлолт

/ Батлагдсан төсөв-15,0 сая төгрөг/

2019.08.27

Ховд хот

1. Хурд сааруулагчийг тодорхой хэсэг газарт замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн хурд хэтрүүлэхээс сэргийлэн, тухайн бүс нутгийг дайран өнгөрөх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурдыг хязгаарлах зорилгоор хэсэгчилсэн бүсийн чанартай авто замын орчинд байрлах сургууль, цэцэрлэгийн дэргэдэх авто замд хавсралтад заасан байршилд суурилуулна.
2. Хурд сааруулагчийг "хурд сааруулагч, Техникийн ерөнхий шаардлага, хэрэглэх дүрэм MNS 5968:2009" стандартад заасны дагуу суурилуулна.
3. Хурд сааруулагч нь халуун хүйтэн орчин болон механик үйлчилгээг тэсвэрлэх чадвартай асфальтан хольцоор хийнэ Хурд сааруулагч хийхдээ авто замд хурд сааруулагчийн өргөнтэй тэнцүү зүсэлт хийж авсны дараа дүүргэлт хийнэ.
4. Хурд сааруулагчийн өргөн 1000 мм, урт нь зорчих хэсгийн өргөнтэй тэнцүү байх ба өндөр нь гол хэсэгтээ 70 мм, 2 зах уруугаа намссан нумарсан хэлбэртэй байвал зохино
5. Хурд сааруулагчийн гадаргуунд цагаан шар өнгийн гэрэл ойлгогч материалаар тэмдэглэл хийх ба цагаан шар өнгө нь тус бүр 45 хэмийн налуу 450-500мм өргөнтэй байвал зохино.
6. Тухайн сургууль, цэцэрлэгийн дэргэдэх авто замд тавигдсан хоёр хурд сааруулагчийн дунд хавсралтад заасан байршилд явган зорчигчийн гарц хийнэ. Гарцыг Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм болон MNS 4759:2003 /замын тэмдэглэл, техникийн ерөнхий шаардлага/, MNS 4596:2007 /замын тэмдэг, тэмдэглэл... хэрэглэх дүрэм/ стандартад заасны дагуу хийх шаардлагтай бөгөөд цагаан өнгийн гэрэл ойлгогч материалаар тэмдэглэл хийнэ. Зарим чиглэлийн авто замд гарц хийхдээ замын нөхцлийг харгалзан үзэж / 3 дугаар сургуулиас баруун гар тийш

эргэх хэсэгт байгаа/ цэцгийн мандлын тодорхой хэсгийг буулгах, дахин тохижуулах ажил хийнэ.

7. Хурд сааруулагч болон явган зорчигчийн гарцыг хийх, замын тэмдгүүдийг байрлуулахад Ховд хотын Захирагчийн ажлын албаны ажилтанууд болон аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн ажилтануудын хяналттайгаар хийнэ.
8. Хурд сааруулагч болон явган зорчигчийн гарцыг хийх, тэмдэг тэмдэглэгээг бэхжих хүртэл тодорхой чиглэлийн замыг хаах зэргээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах үед аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасагтай хамтран ажиллах шаардлагатай.
9. Тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан төлөвлөсөн хурд сааруулагч, гарцийг өөрчлөх, тавихгүй байх тохиолдол гарвал захиалагч гүйцэтгэгч харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.

ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Ховд хотын сургууль, цэцэрлэгийн дэргэдэх авто замд хурд сааруулагч суурьлуулах газрын байршил, хэмжээ

д/д	Сургууль цэцэрлэгийн нэрс	Хурд сааруулагчийн тоо, байршил	Явган зорчигчийн гарцны хэмжээ байршил
1	Прогресс сургууль, 12 дугаар цэцэрлэг 14 дүгээр цэцэрлэг	тоо-2ш: -гарцаас хойш 49 метр зайд "Сургуулийн бүсийн төгсгөл" гэсэн тэмдгийн дэргэд, цэцэрлэгийн хашааны хойт өнцөгтэй ижил түвшинд -Гарцаас урагш 49 м зайд "гарц" тэмдгийн дэргэд	Буянт өрхийн ЭМТ-н өмнөх зогсоол болон Жаргалант сумын Тамгын газрын 12 айлын орон сууцны дэргэдэх авто зогсоолын дундах шороон зурвасын өргөнтэй тэнцүү /7м /, зам хөндлөн гарц шинээр хийх
2	Цаст Алтай цогцолборын бага сургууль	тоо-2ш: -Төрийн банкны дэргэдэх одоогийн гарцнаас хойш 3 метр зайд - Голомт банкны дэргэдэх одоогийн гарцнаас урагш 3 метр зайд	-Төрийн банкны дэргэдэх одоогийн гарцыг тодруулах ---Голомт банкны дэргэдэх одоогийн гарцыг тодруулах Гарцын өргөн 3м
3.	1 дүгээр сургууль	тоо-2ш: Одоогийн гарцнаас хоёр тийш 12 метр зайд	Одоогийн гарцыг сэргээн тодруулах
4	6 дугаар сургууль	тоо-2ш: -Автобусны буудлын дэргэдэх одоо байгаа гарцны шууд өмнө буюу 3м зайд, -3 замын уулзварын доод талын гарцны шууд өмнө буюу 3 м зайд	-Сургуулийн урд талын авто замд байгаа одоогийн 2 гарцыг сэргээн тодруулах

5	8 дугаар цэцэрлэг	Тоо-2ш: -Цэцэрлэг талын автобусны зогсоолын хойд өнцгөөс 3м газарт шинээр хийх гарцнаас 3м зайд /10 мянгат талд/ - Өгөөмөр дэлгүүр талд байгаа хуучин гарцны урд талд	Тоо-2ш: -Цэцэрлэг талын автобусны зогсоолын хойд өнцгөөс 3м газарт гарц шинээр хийх -Өгөөмөр дэлгүүр талд байгаа хуучин гарцыг тодруулах
6	Цагаан морь захын дэргэдэх авто зам	тоо-1 ус нэвтрүүлэх хоолойн дээр	
7	8 дугаар цэцэрлэгийн дэргэдэх авто зам	тоо-1 ус нэвтрүүлэх хоолойн дээр	

ХОВД ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА

Тав. Зураг

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 43.040.80

Хурд сааруулагч. Техникийн ерөнхий шаардлага, хэрэглэх дүрэм	MNS 5968 : 2009
Speed Humps. General technical requirements and use rules	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2009 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 15 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2009 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэхүү стандартын үзүүлэлт, шаардлагыг заавал мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь эзэмшлийн хэлбэрээс үл хамааран тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлахаар зорчих хэсэгт байрлуулсан хурд сааруулагчийг төлөвлөх, суурилуулах, ашиглалтын үндсэн шаардлагыг тогтооход хамаарна.

2 Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах хүчин төгөлдөр мөрдөж байгаа дүрэм, стандартуудыг иш татан хэрэглэсэн. Иш татсан стандартад өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн хамгийн сүүлийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ.

- Монгол Улсын Замын Хөдөлгөөний Дүрэм.
- MNS 4597:2003, Замын тэмдэг, техникийн ерөнхий шаардлага.
- MNS 4759:2003, Замын тэмдэглэл техникийн ерөнхий шаардлага.
- MNS 4596:2007, Замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм.

3 Нэр томъёо ба тодорхойлолт

3.1 Хурд сааруулагч – Тодорхой хэсэг газарт замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн хурд хэтрүүлэхээс сэргийлэн, тухайн бүс нутгийг дайран өнгөрөх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурдыг хязгаарлах зорилгоор суурилагдсан хэрэгсэл.

3.2 Тээврийн хэрэгсэл - Хүн (зорчигч) ба ачаа, суурилагдсан тоног, төхөөрөмжийг замаар тээвэрлэхэд зориулсан хэрэгсэл.

3.3 Бүх жин - Тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолтоор тогтоосон өөрийн болон ачаа, жолооч, зорчигчийн нийт зөвшөөрөгдөх дээд жин. Чиргүүл нь тухайн тээврийн хэрэгслийн бүтцэд хамаарагдах бол бүх жинг чирэгч, чиргүүл хоёрын бүх жингийн нийлбэрээр тооцно.

3.4 Хүнд даацын ачааны автомашин - Бүх жин нь 3500 кг-аас их ачааны автомашин.

MNS 5968 : 2009

3.5 Хэсэгчилсэн бүсийн чанартай авто зам - Гол замаас салбарласан авто зам.

3.6 Хэвтээ тэмдэглэл – Замын хөдөлгөөнд тодорхой горим, журам тогтоох зорилгоор зорчих хэсэг буюу түүний хашлага дээр хийсэн шугам, сум зэрэг бичлэг тэмдэглэл.

4 Хурд сааруулагчийн төрөл

4.1 Тээврийн хэрэгслийн нэг чигийн хөдөлгөөнтэй болон хэсэгчилсэн бүсийн чанартай авто замын орчимд байрлах сургууль, цэцэрлэгийн дэргэдэх авто замд тавигдана.

-Энэхүү хурд сааруулагч нь:

Өндөр нь - 70 мм,

Өргөн нь - 4200 мм ба зорчих хэсгийн өргөнтэй тэнцүү урттай тавигдана.

(С.хавсралтын С.1, С.2 – зураг)

4.2 Үзэгдэх орчин хязгаарлагдсан үед гарцны өмнө тавигдаж болно.

-Энэхүү хурд сааруулагч нь:

Өндөр нь - 50 мм,

Өргөн нь - 350 мм ба зорчих хэсгийн өргөнтэй тэнцүү урттай тавигдана.

(С.хавсралтын С.3, С.4 – зураг)

4.3 Үзэгдэх орчин хязгаарлагдсан үед гарцны өмнө тавигдаж болно.

-Хүнд даацын ачааны автомашин явахад зөвшөөрөгдсөн замд зориулсан хурд сааруулагч нь:

Өндөр нь - 75 мм,

Өргөн нь - 900 мм өргөн, зорчих хэсгийн өргөнтэй тэнцүү урттай тавигдана.

(С.хавсралтын С.5, С.6 – зураг)

4.4 Замын зорчих хэсэгт "Хурд сааруулагч" –ыг хэвтээ тэмдэглэлээр хийж болно. Хэвтээ тэмдэглэлийг дангаар нь буюу тэмдэгтэй хослуулан хэрэглэнэ.

(С.хавсралтын С.9 – зураг)

5 Хурд сааруулагчийг байрлуулахад тавих шаардлага

5.1 Хурд сааруулагч нь халуун, хүйтэн орчинд болон механик үйлчилгээг тэсвэрлэх чадвартай нийлэг /синтез/ буюу резинэн материалаар хийгдсэн байна. Мөн асфальтан хольц болон цементэн бетоноорхийж болно.

5.2 "Хурд сааруулагч" мэдээлэх тэмдгийг хурд сааруулагчийн шууд өмнө тавьсан байна. (В.хавсралт, С.хавсралтын С.8 - зураг)

5.3 Хурд сааруулагч тавигдсан газраас 50 метрээс 100 метрт анхааруулах тэмдгийг тавьсан байна. (А. хавсралт, С.хавсралтын С.8 - зураг)


5.4 Хурд сааруулагчийн гадаргуунд цагаан, шар өнгийн гэрэл ойлгогч материалаар тэмдэглэл хийсэн байна. (С.хавсралт С.7 – зураг)

ТӨГСӨВ.

**А.хавсралт
(норматив)**

А. "ХУРД СААРУУЛАГЧ" АНХААРУУЛАХ ТЭМДЭГ

"Бусад аюултай газар" /1.27/ тэмдгийн үйлчлэх хүрээнд тавигдах "Хурд сааруулагч" гэсэн нэмэлт тэмдгийн дүрс болон техникийн үзүүлэлтүүд




"Замын хөдөлгөөний дүрэм"-ийн 1-р хавсралтын 22-р зүйлд заасны дагуу нэмэлт тэмдгийг цэнхэр дэвсгэр дээр хийнэ.



	H [мм]	B [мм]	r [мм]
Нэг эгнээтэй замд	300	600	40
Хоёр буюу 3 эгнээтэй замд	350	700	
4 буюу түүнээс олон эгнээтэй замд	450	900	

Эмкээрийн өргөн: 10 мм
Жич: Нэмэлт тэмдгийн "B" хэмжээ нь дамт тавигдах 1.27 тэмдгийн өргөнтэй тэнцүү байна.

Масштабын торон дээрх тэмдгийн дүрс



Жич: Тэмдгийн дүрсийг зохих хэмжээнд нь хүртэл томсгоход масштабын тор буюу фото зургийн арга, эсвэл компьютер графикийн аргыг хэрэглэнэ.

**В.хавсралт
(норматив)**

В. "ХУРД СААРУУЛАГЧ" МЭДЭЭЛЭХ ТЭМДЭГ

"Хурд сааруулагч" мэдээлэх тэмдгийн дүрс болон техникийн үзүүлэлтүүд

Тэмдгийн дүрс




"Замын хөдөлгөөний дүрэм"-ийн 1-р хавсралтын 22-р зүйлд заасны дагуу тэмдгийг цэнхэр дэвсгэр дээр хийнэ.



	В [мм]	г [мм]
Нэг эгнээтэй замд	600	40
Хоёр буюу 3 эгнээтэй замд	700	
4 буюу түүнээс олон эгнээтэй замд	900	

Эмхээрлийн өргөн: 10 мм

Масштабын торон дээрх тэмдгийн дүрс



Жич: Тэмдгийн дүрсийг зохих хэмжээнд нь хүртэл томсгоход масштабын тор буюу фото зургийн арга, эсвэл компьютер графикийн аргыг хэрэглэнэ.


**С.хавсралт
(норматив)**

С.1. Тээврийн хэрэгслийн нэг чигийн хөдөлгөөнтэй болон хэсэгчилсэн бүсийн чанартай авто замын орчимд байрлах сургууль, цэцэрлэгийн дэргэдэх авто замд тавигдах хурд сааруулагч.



С.1 – зураг


С.2. Тээврийн хэрэгслийн нэг чигийн хөдөлгөөнтэй болон хэсэгчилсэн бүсийн чанартай авто замын орчимд байрлах сургууль, цэцэрлэгийн дэргэдэх авто замд тавигдах хурд сааруулагч байршуулах жишээ.



С.2 – зураг


С.хавсралтын үргэлжлэл

С.3. Үзэгдэх орчин хязгаарлагдсан гарцын өмнө тавих хурд сааруулагч



С.3 - зураг


С.4. Үзэгдэх орчин хязгаарлагдсан гарцын өмнө тавих хурд сааруулагч байршуулах жишээ.



С.4 – зураг


С.хавсралтын үргэлжлэл

С.5. Хүнд даацын ачааны автомашин явахад зөвшөөрөгдсөн замд тавих хурд сааруулагч



С.5 – зураг


С.6. Хүнд даацын ачааны автомашин явахад зөвшөөрөгдсөн замд тавих хурд сааруулагч байршуулах жишээ.



С.6 – зураг


С.хавсралтын үргэлжлэл

С.7. Хурд сааруулагчийн гадаргууд гэрэл ойлгогч материалаар хийгдэх тэмдэглэл.




С.7 - зураг

С.8. "Хурд сааруулагч" анхааруулах, мэдээлэх тэмдэг байрлуулах жишээ.



С.8 – зураг



С.9 - зураг

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**
ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- | | |
|-------------------------------------|---|
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ² дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |

² Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх** 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь** 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх** 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги** 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги³ төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах** 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежер тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтгэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага** 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

³ Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ⁴

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: [Хотын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн орчимд байгаа авто замуудад хурд сааруулагч хийх ХОАЖСЗДТГ/201902001]
ГЕН 2.1	Ажил нь <i>[техникийн тодорхойлолт, зураг, төсөв, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал]</i> -аас бүрдэнэ. Ажлын талбай нь <i>[Жаргалант сумын сургууль цэцэрлэгүүдийн орчим]</i> -д байрших болно.
ГЕН 3.1	Төслийн менежер нь <i>[Хотын захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн Х.Баярлах]</i>
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр <i>[2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр]</i> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>[2019 оны 10 дугаар сарын 31-ны өдөр]</i> ⁵
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <i>[5]</i> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа <i>[365]</i> хоног байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>[хувь]</i> байна. ⁶ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>[10 хувь]</i> байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <i>[мөнгөн дүн]</i> байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <i>[хувь]</i> -иар тооцно.

⁴ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁵ Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

⁶ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Гарын үсэг)

_____ (Албан тушаал)

ГҮЙЦЭТГЭГЧ

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Гарын үсэг)

_____ (Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр эхэлж, _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;

- 5.8.** Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
5.9. Санхүүжилтийн хуваарь;
5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 6.** Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
- 7.** Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.
- 8.** Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 9.** Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]